

**“БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ  
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол, Япон хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь айлчлал солилцоо, цэргийн мэргэжилтэн бэлтгэх, Хуурай зам, Агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, Инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хөгжиж ирсэн.

Өнөөгийн байдлаар батлан хамгаалах салбарын хэмжээнд хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаварыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”, Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг” (2024 оны 02 дугаар сард шинэчилсэн), 2022 онд “Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Япон Улсын Агаарын Өөрийгөө хамгаалах хүчин хоорондын Агаарын цэргийн салбар дахь хамтын ажиллагаа болон солилцооны санамж бичиг”-ийг тус тус байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны харилцааг “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-д хүргэж, түвшингээ ахиулсан. Энэхүү тусгай стратегийн түншлэлийн хүрээнд “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулах асуудлыг хоёр талаас харилцан тохиролцсон.

Энэхүү хэлэлцээр нь соёрхон батлах олон улсын гэрээ тул хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар зөвшилцсөний үндсэн дээр 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Хэлэлцээр нь долоон зүйлтэй, батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж, технологи шилжүүлэх харилцааг зохицуулах хоёр талын цэрэг-техникийн хамтын ажиллагааны ерөнхий гэрээ болно. Хэлэлцээрийг Монголын талаас хэрэгжүүлэгчээр Монгол Улсын Батлан хамгаалах яам, Японы талаас Япон Улсын Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам байна.

Хэлэлцээрийг таван жилийн хугацаатай байгуулах бөгөөд үүнээс хойш аль нэг талаас бичгээр энэхүү хэлэлцээрээс гарах тухай илэрхийлээгүй бол нэг, нэг жилээр сунгагдана.

Засгийн газар хоорондын тус хэлэлцээрийг соёрхон баталснаар хоёр улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.

Мөн Япон улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэх, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах.

Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР